БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Ч. МӨНХТУЯА

2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

# AUTOCAD CIVIL 3D ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны эрхлэн явуулдаг Нислэгийн зургийн үйлчилгээний хүрээнд боловсруулагдах бүтээгдэхүүнүүдийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Чикагогийн конвенцын Хавсралт 4-ын дагуу боловсруулах үйл ажиллагаанд ашиглах AutoCAD Civil 3D программ хангамжийн шаардлага, үзүүлэлтийг тусгасан техникийн тодорхойлолт болно.

## 2. ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТАВИГДАХ ШААРДЛАГА БА БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

2.1. Ажилд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан программ хангамж түүний лиценз.

2.2. Нийлүүлэгч нь программ хангамжийн нь лицензийг үйлдвэрлэгч байгууллагаас авсан албан ёсны баримт.

2.3. Нийлүүлэх бүтээгдэхүүн нь AutoDesk компанийн албан ёсны лиценз бүхий AutoCAD Civil 3D программ хангамжийн 2023 эсхүл түүнээс хойших хувилбар байна.

## 3. ТУСГАЙ ШААРДЛАГА

3.1. Нийлүүлэгч нь баталгаат хугацаанд техник үйлчилгээ, гэмтэл саатал засварлах, компьютер шилжүүлэх, шинэ хувилбараар сайжруулах зэрэг үйл ажиллагааг үнэ төлбөргүй хийж гүйцэтгэнэ.

3.2. Программ хангамжийн албан ёсны лицензийн хугацаа нь 1 жил эсхүл түүнээс дээш хугацаатай байна. Хугацаагүй хувилбар санал болгосон тохиолдолд давуу тал болно.

## 4. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Д/д | Программ хангамжийн нэр | Техникийн үзүүлэлт | Шаардлага |
|---|---|---|---|
| 1 | AutoCAD Civil 3D 2023 | • Систем<br>• Лиценз төрөл<br>• Технологи<br>• Платформ | • Windows 10 болон түүнээс дээш үйлдлийн системийн 64bit хувилбарт ажилладаг<br>• Лиценз нь anyway<br>• Үүлэн технологи (Cloud) дэмждэг<br>• Esri ArcGIS программ хангамжийг дэмждэг |

## 5. НИЙЛҮҮЛЭХ ТОО ШИРХЭГ

| № | Программ хангамжийн нэр | Хэмжих нэгж | Нийлүүлэх тоо | Лицензийн хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | AutoCAD Civil 3D 2023 | ш | 2 | 2 жил |

## 6. ХҮЛЭЭН АВАХ

6.1. Нийлүүлэгч нь ИНҮТ-ийн НМҮА-нд программ хангамжийг суурилуулж, бүрэн ажиллуулж, хүлээлгэж өгнө.

6.2. Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан программ хангамжийн иж бүрдлийн хамт нийлүүлнэ.

6.3. Программ хангамжийн гарын авлага хамт нийлүүлнэ.

6.4. Нийлүүлэгч нь гэрээнд гарын үсэг зурагдаж баталгаажсанаас хойш ажлын 20 хоногийн дотор иж бүрдлийг хүлээлгэн өгнө.

6.5. ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

6.6. Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.

**Техникийн тодорхойлолт боловсруулсан:**

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны
Тогтмол мэдээллийн хэсгийн тоон мэдээллийн
тасгийн ахлагч инженер,
Үнэлгээний хорооны дарга: Г. Энхтүвшин

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг: Б. Алтангэрэл

"Инженер технологийн үндэсний төв"
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн: Я. Алтантунгалаг